

БАТЛАВ: НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН С.БАТБОЛД



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2018 оны 01 дүгээр сарын

Улаанбаатар хот

№	Засгийн газрын 2016-2020 оны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үе шат	Хугацаа												Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Төсөв /мян.төг/	Хариуцах/Хамтран хэрэгжүүлэх нэгжийн нэр		
				1 улирал			2 улирал			3 улирал			4 улирал								
				1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12						
Нэг. Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан үйл ажиллагаа																					
1	1.6.5 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах үйл ажиллагааны сонгон шалгаруулалтыг ил тод болгож, иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг нэмэгдүүлнэ.	1-74. Худалдан авах ажиллагааны нэгдсэн системийг хэмжээнд нэвтрүүлэн, захиргааны байгууллагуудыг тухайн системд нэгтгэх ажлыг хэрэгжүүлж бүрэн ил тод нээлттэй болгоно.																			
	1.1. Нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль, журам болон Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын 2017 оны 337 дугаар тогтоолд нийцүүлэн зохион байгуулах, хэрэгжүүлэх асуудлаар 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албад, Нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудад заавар, зөвлөмж хүргүүлнэ.																	Хугацаагаар	2018 оны 4 дүгээр сард багтаан гүйцэтгэсэн байх.	ХААХ / XX, ЗСХ	
	1.2. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн ашиглалт болон худалдан авах ажиллагааны хууль, журмын талаар сургалтыг 2 удаа зохион байгуулж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, Дүүргийн Худалдан авах ажиллагааны албад, Нийслэлийн төсөвт болон аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын 100-120 албан хаагчийг хамруулна.																	Сургалтанд хамруулсан албан хаагчийн тоогоор	100-120 албан хаагчийг хамруулах	1,000.0	ХААХ, МТХ
	1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журам, Засгийн газрын тогтоол болон Нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажилласан эсэх талаар Дүүргийн Худалдан авах ажиллагааны албадад хяналт тавьж, шалган зааварлах ажлыг 9-10 дугаар сард багтаан зохион байгуулна.																	Ажлын явцаар	Дүгнэлт, зөвлөмж гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байх.	ХААХ / XX, ЗСХ, МТХ	
	1.4. Нийслэлд нэвтрүүлж буй дундын мэдээллийн орон.ulaanbaatar.mn системийг бүрэн ашиглаж, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг хууль, журмын дагуу ил тод, шуурхай мэдээлнэ.																	Гүйцэтгэлийн хувиар	Шардлагатай мэдээллийг системд 100 хувь нийтлэсэн байх.	ХААХ, МТХ	
	1.5. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас тус газарт эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр уг цахим систем болон өөрийн байгууллагын www.ub-procurement.mn цахим хуудаст оруулж, тендерийн урилгыг өдөр тутмын сонинд нийтлэн олон нийтэд мэдээлнэ.																	Гүйцэтгэлийн хувиар	Худалдан авах ажиллагааг 100 хувь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр зохион байгуулж, үр дүнг ил, тод, нээлттэй мэдээлсэн байх	32,475.0	ХААХ, МТХ
	1.6. Тендерт оролцогч аж ахуйн нэгж, иргэний төлөөлөлд хууль, журмыг сурталчлах, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ийн ашиглалтыг дэмжих чиглэлээр сургалт зохион байгуулна.																	Сургалтанд хамруулсан төлөөллийн тоогоор	Аж ахуйн нэгжийн 80-100 төлөөллийг хамруулна	1,500.0	ХААХ / МТХ
	1.7. Төсвийн Ерөнхийлөн захирагчаас 2018 онд хэрэгжүүлсэн худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу нэгтгэж, Нийслэлийн дотоод аудитын албаар хянуулан, 2019 оны 01 сарын 15-ны өдрийн дотор Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.																	Журмын хэрэгжилтээр	Хуулийн хугацаанд багтаан Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлсэн байх.	ЗСХ / ХААХ	

Хоёр. Дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

2	2.1. Нийслэлийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын дагуу боловсруулан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар батлуулах, Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) болон өдөр тутмын сонинд нийтлэх ажлыг хугацаанд нь хийнэ.																				Хууль, журмын хэрэгжилтээр	Журмаар батлагдсан маягтын дагуу боловсруулж, хуулийн хугацаанд багтаан гүйцэтгэсэн байх.	1,000.0	3CX, XAAX, MTX	
	2.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 4.7.4-дэх заалтын дагуу үнэлгээний хороонд иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулж, урамшуулал олгоно.																					АЗ гэрчилгээтэй иргэний төлөөллийг нэмэгдүүлсэн тоогоор	АЗ гэрчилгээтэй иргэний төлөөллийг НИТХ-аар хэлэлцүүлэн, тогтоолоор батлуулсан байх.	6,300.0	XAAX / XX, 3CX, MTX
	2.3. Төсөвт байгууллагын өөрийн орлогыг батлагдсан төсөв сар, улирлын хуваарийн дагуу төсөвт төвлөрүүлнэ.																					Гүйцэтгэлийн хувиар	Төсвийн хуваарийн дагуу орлого төвлөрүүлсэн байх.	20,000.0	3CX
	2.4. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны тухай хууль, Шилэн дансны цахим хуудаст тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартын тогтоох тухай" журмыг хэрэгжүүлэн ажиллана.																					Стандартаар	Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг олон нийтэд хугацааны хоцрогдолгүй, стандартын дагуу мэдээлсэн байх.		3CX / XX, XAAX
	2.5. Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол маргааныг хууль, журмын дагуу шийдвэрлүүлэх, гомдлын бүртгэл үүсгэн, судалгаа, дүгнэлт хийх, түүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.																					Гүйцэтгэлийн хувиар	Гомдлын тоог бууруулсан байх.		XX, XAAX
	2.6. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль" болон холбогдох журам, жишиг бичиг баримтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраар уламжлан Төсвийн асуудал эрхэлсэн Төрийн Захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.																					Ажлын явцаар	Санал хүргүүлсэн байх.		XX / XAAX
	2.7. Төрийн дээд шатны болон Нийслэлийн нутгийн захиргааны удирдах байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, зааврын дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.																					Ажлын явцаар	Тухайн чиглэлээр үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлсэн байх.		XAAX, XX, 3CX, MTX
	2.8. Худалдан авах ажиллагааны явцад гарсан зөрчлийг судлах, түүнийг залуулах, худалдан авах ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох, сайн туршлагыг нэвтрүүлэх арга хэмжээг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.																					Ажлын явцаар	2018 оны 3 дугаар улиралд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран "Туршлага судлах 1 өдөр" уулзалт, танилцуулгыг зохион байгуулсан байх.		XX / XAAX
	2.9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл, Сангийн сайдын 2007 оны 81 дүгээр тушаалаар батлагдсан "Тендерт оролцогчид давуу эрх тооцох аргачлал"-ын дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцно.																					Гүйцэтгэлийн хувиар	Тендер бүрт дотоодын давуу эрх тооцсон байх.		XAAX / XX
	2.10. Бараа худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа үндэсний үйлдвэрлэлийн барааг импортоор ирж байгаа бараанаас тусад нь багцлах ба Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолын дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар, стандартын шаардлага хангасан барааны жагсаалтад заасан барааг нийлүүлэх тухай шаардлагыг тендерийн баримт бичигт тусгана.																					Гүйцэтгэлийн хувиар	Бараа нийлүүлэх тендер бүрт уг заалтыг хэрэгжүүлсэн байх.		XAAX / XX
	2.11. Худалдан авах ажиллагааны чанар, үр дүнгийн талаар тендерт оролцогч аж ахуйн нэгжүүдийн сэтгэл хангамжийг тодорхойлох судалгаа зохион байгуулах, үр дүнд үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллана.																					Гүйцэтгэлийн хувиар	Үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх талаар төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлсэн байх.	2,000.0	XAAX / 3CX, XX, MTX
	2.12. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж, Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.																					Гүйцэтгэлийн хувиар	Бодлогын баримт бичгийн биелэлтийг улирал тутамд 25 хувь хангаж, бүрэн, үнэн зөв тайлагнасан байх.		3CX / XAAX, XX, MTX
	2.13. Тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу тайланг холбогдох байгууллагад хүргүүлнэ.																					Гүйцэтгэлийн хувиар	Тогтоол шийдвэр, удирдлагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг улирал тутамд 25 хувь хангаж, бүрэн, үнэн зөв тайлагнасан байх.		3CX / XAAX, XX, MTX

2.14. Байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнд үнэлгээ хийх, ажил эрчимжүүлэх дүгнэлт гаргах ба биелэлтийг 100 хувь хангаж мэдээ, тайланг Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу холбогдох байгууллагад хүргүүлнэ.											Гүйцэтгэлийн хувиар	Нийслэлийн Засаг Даргын 2017 оны 335 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг улирал тутамд 25 хувь хангаж, тайлан мэдээг хуваарийн дагуу бүрэн хүргүүлсэн байх.			3СХ / ХААХ, ХХ, МТХ
2.15. Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Монгол Улсын Сангийн сайдын баталсан Нягтлан бодох бүртгэлийн тайлагналын заавар, журмыг хэрэгжүүлэн ажиллана.											Хууль, журмын хэрэгжилтээр	Хууль, журам, стандартыг мөрдөж ажилласан байх.	438,009.7		3СХ-ийн ахлах нягтлан бодогч
2.16. Байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт болон хангамжийн материалын зарцуулалтыг сайжруулах, тооллого бүртгэлийг тогтсон хугацаанд явуулах.											Тооллого, үнэлгээ хийсэн тоогоор	Санхүүгийн тайланд бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлыг 2018 оны 02 дугаар сард, Үндсэн хөрөнгийн тооллогыг жилд 1 удаа, хангамжийн материалын тооллогыг хагас жилд 1 удаа тус тус зохион байгуулсан байх.			3СХ
2.17. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллана.											Цахим хуудсын мэдээллийн багтаамжаар	Хууль, журмаар заасан мэдээллийг цахим хуудаст бүрэн нийтэлсэн байх.			МТХ/ 3СХ, ХААХ, ХХ
2.18. Тус байгууллагаас 2017 онд баталсан "Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөөг гаргаж, биелэлтийг хангаж ажиллана.											Гүйцэтгэлийн хувиар	Төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байх.	5,000.0		3СХ/ ХААХ, ХХ, МТХ
2.19. Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалтуудын эрэлт хэрэгцээг тодорхойлон төлөвлөгөө баталж, холбогдох төрийн болон сургалтын байгууллагатай хамтран сургалт зохион байгуулах.											Сургалтад хамруулсан албан хаагчийн тоо	Албан хаагчдыг 100 хувь хамруулсан байх.	1,420.0		3СХ / ХААХ, ХХ, МТХ
2.20. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, хууль тогтоомж болон Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллана.											Гүйцэтгэлийн хувиар	Төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байх.	80.0		3СХ / ХААХ, МТХ, ХХ
2.21. Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлж, Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох хууль тогтоомж, албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллана.											Сургалт зохион байгуулсан тоогоор	Ёс зүйн зөрлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 5-6 удаа зохион байгуулсан байх.			3СХ, ХААХ, ХХ, МТХ
2.22. Архивын тухай хууль, Байгууллагын архивын үндсэн заавар, Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу удирдлагын баримт болон тендерийн материалыг 1 дүгээр улиралд багтаан архивлана.											Хугацаагаар	Шинээр архивын нэгж үүсгэх ажлыг 1 дүгээр улиралд багтаан дууссан байна.	3,836.8		3СХ / ХААХ, ХХ, МТХ
2.23. Иргэдээс байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдол санал хүсэлтийг www.smartcity.mn /ub.1200.mn/ цахим системээр хүлээн авч, ажлын 5 хоногт багтаан үндэслэлтэй шийдвэрлэнэ.											Шийдвэрлэлтийн дундаж хугацаагаар	Ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.			3СХ, ХААХ, ХХ, МТХ
2.24. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн "eDOC" системийг стандартын дагуу хөтөлнө.											Зөрчилгүй шийдвэрлэлтээр	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэвшүүлсэн байна.	3,800.0		3СХ / ХААХ, ХХ, МТХ
НИЙТ ДҮН															496,421.50

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ УРСГАЛ ЗАРДАЛ

НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГҮНДСАМБУУ

УХА0517 5664225